



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/21

Номгон

Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн ажлуудыг зохион байгуулж, 2023 оны батлагдсан төсөвт өртгийг хуваарилан зарцуулах тухай

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тус тус заасан "Тогтвортой хөдөө аж ахуй" зорилгын хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар малын тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дах заалт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн XIII.1.15, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Аймаг орон нутагт эрх шилжүүлэх хуваарь батлах тухай" А-58 дугаартай тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн XIII.1.15 дугаарт батлагдсан "Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл"-ийн хүрээнд Хөдөө аж ахуйн кластерийн барилга, байгууламж, гүн өрмийн худаг, хашаажуулалт, тариалангийн талбайн цахилгааны станц, дэд станц, хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, гадна тохижилт, хүрмэн бетон хашаа, хүлэмжийн ажлуудыг зохион байгуулсугай.


2. Хөрөнгө оруулалтын томоохон төслүүд болон бүс, орон нутгийн хэмжээнд дээрх ажлуудын тооцоо судалгааг гаргаж холбогдох зураг төсвийг хийлгэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

642310049

2.

3.Монгол Улсын 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн XIII.1.15 дугаарт батлагдсан “Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл”-ийн 2023 онд батлагдсан 4,201.0 сая төгрөгийг хавсралтын дагуу хуваариар баталж төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

4.“Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл”-ийн ажлын зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын *М.Б.* оны *01* дүгээр сарын *19* ны өдрийн *104* дүгээр захирамжийн хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН КЛАСТЕР ТӨСЛИЙН  
ГАЗАР ТАРИАЛАН, МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН  
ДЭД ТӨСӨЛ /Сая.төг/**

Багц	Төслийн нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	Гэрээний дүн	2022 онд санхүүжих дүн	2023 онд санхүүжих дүн	Нийт хувь
1	Хөдөө аж ахуйн кластерийн барилга байгууламжийн ажил	2022	2023	3,315.0	3315.1	100	1,390.0	45
2	Гүн өрмийн худаг, Ногоон тэжээлийн газрын хашаажуулалт	2022	2023	388.0	373.94	50	323.9	100
3	Тариалангийн талбайн цахилгаан станц, дэд станцын ажил	2022	2023	202.8	191.311	28	63.3	48
4	Хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж	2022	2023	2,954.8	2835.2	52	940.2	35
5	Хөдөө аж ахуйн гадна тохижилт, хүрмэн бетон хашаа	2022	2024	1,252.6	1173.9	250	724	83
6	Хүлэмжийн барилгын ажил	2023	2024	1,886.6	1,886.6	0	760	40
	<b>Нийт дүн</b>			<b>10,000.0</b>	<b>9,776.0</b>	<b>480</b>	<b>4,201.4</b>	